



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2018.02.26 № 06/19

танай _____ -ны № _____ -т

Г _____ Г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймаг дахь Цагдаагийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хэнтий аймаг дахь Цагдаагийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хэнтий аймаг дахь Цагдаагийн газрын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага


Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн

0600357

болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР**

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2017
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

Аудитын тайлан

ТАБ-ын Тэргүүлэх аудитор:
Ч.Эрдэнэбаатар
Утас: 70562112
Цахим хаяг: Khentii@audit.gov.mn

Хавсралт 1: Агуулга
Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
Хавсралт 3: Менежментийн захидал
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 70562147
Цахим хаяг:

Аудитор: Х.Еркегүл
Утас: 70562147
Цахим хаяг: erkegulkh@audit.gov.mn

ТАБ-ын хаяг
Байршил: Хэнтий аймаг Хэрлэн сум
3-р баг АЗДТГ-ын байр
Цахим хуудас: Khentii@audit.gov.mn

2018 оны 02 дугаар сар

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:.....	3
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:.....	3
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:.....	3
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:.....	4
5. Дотоод хяналт:.....	5
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:.....	5
7. Шилэн дансны мэдээлэл.....	5
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:.....	5
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:.....	5
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:.....	5
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:.....	6
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:.....	6
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:.....	6
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:.....	6
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:.....	7
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:.....	7

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймаг дахь Цагдаагийн газрын төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд /ХЭА-2018/71/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Хэнтий аймаг дахь Цагдаагийн газрын 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Хэнтий аймаг дахь Цагдаагийн газрын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 25 -наас 2018 оны 02 дугаар сарын 25-ныг хүртэл хийхээр төлөвлөн ТАБ-ын аудитор Х.Еркегүл хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Хэнтий аймаг дахь Цагдаагийн газрын төсвийн 2017 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг 2018 оны 01 дүгээр сарын 25-нд ТАБ-д ирүүлсэн байна.

ТАБ аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 31 -нээс 2018 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 02 дугаар сарын 25-нд байгууллагын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомжид өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Цагдаагийн газар нь Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Хууль зүйн яам, Цагдаагийн байгууллагын шинэчлэлийн бодлого, дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлж, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлын арга, хэлбэрийг боловсронгуй болгох, олон нийт цагдаагийн хамтын ажиллагааг сайжруулах, цагдаагийн үйлчилгээг иргэдэд шуурхай, хүртээмжтэй хүргэх, албан хаагч бүрийн ажлын бүтээлч чанар, үр дүнг ахиулж, аюулгүй байдал, нийгмийн баталгааг хангах” гэж тодорхойлсон эрхэм зорилгын дор Цагдаагийн ерөнхий газрын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаагаа эрхлэн гүйцэтгэж байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасны дагуу Хэнтий аймаг дахь Цагдаагийн газрын дарга Төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн төсвийг ЦЕГ-аас олгож байна.

Төсвийн тухай хуулийн 16.5 дугаар зүйлд “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад хяналт тавих, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах” гэж заасан байна.

Төсвийн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой хуулиуд бүрэн хэрэгжиж байна.

Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Төсвийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Хэнтий аймаг дахь Цагдаагийн газрын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын 9 хяналтын горим, нарийвчилсан сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ТШЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Төсвийн захирагчийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн програмаар боловсруулж байгаа бөгөөд байгууллагын дотоод хяналтын эрсдлийг төлөвлөлтийн үед дунд гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Хэнтий аймгийн Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Төсвийн захирагч нь 2017 онд улсын төсвөөс урсгал болон хөрөнгийн зардалд 2,317.1 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас урсгал зардалд 2,309.8 сая төгрөгийг зарцуулж, 7.3 сая төгрөгийн үлдэгдлийг төвлөрүүлсэн байна. Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого 91.3 сая төгрөг батлагдсан ба төлөвлөгөөг 102 хуваар давуулан биелүүлсэн байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6-р зүйлд заасан дараах мэдээллүүдийг шилэн дансны цахим хуудсанд бүрэн байршуулж ажилласан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 9 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын болон нарийвчилсан нийт 9 горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаврыг тодорхойлж чадвал: Үндсэн үйл ажиллагааны орлогын 4.0 сая төгрөгийг шийдвэргүйгээр нэмэлт төсвийн дансанд шилжүүлэн авч зарцуулсан, туслах үйл ажиллагааны орлогын 3.4 сая төгрөгийг төсвийн дансанд тушаахгүй төсвөөс гадуур зарцуулсан, цалингийн зардлаас 6.8 сая төгрөгийг НДШ-ийн зардалд шилжүүлэн зарцуулсан, үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагааны зардалд зориулж 5.4 сая төгрөгийг малчны цалинд олгосон, 13 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгосон, 22 албан хаагчийн албан тушаалын цалингийн шатлал ахиулсан зэрэг

алдаа зөрчил нь Төсвийн тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Төсвийн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.

Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа зөрчил илэрлээ. Үүнд:

1. Үндсэн үйл ажиллагааны орлогын 4.0 сая төгрөгийг шийдвэргүйгээр нэмэлт төсвийн дансанд шилжүүлэн авч зарцуулсан нь Сангийн сайдын 2017 оны 216 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын 3.6-д “Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогын давсан хэсгийг энэ журамд заасны дагуу шийдвэр гарсны дараа нэмэлт төсвийн дансанд шилжүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Сангийн сайдын 2017 оны 216 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

2. Туслах үйл ажиллагааны орлогын 3.4 сая төгрөгийг төсвийн дансанд тушаахгүй, төсвөөс гадуур зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-д “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Ноолуурын орлогыг төсвөөс гадуур зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, харилцах дансандаа тушааж холбогдох журмын дагуу зарцуулж байх зөвлөмж өгөв.

3. Цалингийн зардлаас 6.8 сая төгрөгийг НДШ-ийн зардалд шилжүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар”-т нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг мөрдөж ажиллан, батлагдсан төсвийн зарлагыг эдийн засгийн ангиллын дагуу бүртгэж байх зөвлөмж өгөв.

4. Үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагааны зардалд зориулж 5.4 сая төгрөгийг малчны цалинд олгосон нь Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3-д “Үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагааны зардалд зориулж шууд болон шууд бусаар хөрөнгө зарцуулахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3-д “Үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагааны зардалд зориулж шууд болон шууд бусаар хөрөнгө зарцуулахыг хориглоно” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

5. 2017 оны 5 сарын 1-нээс хойш нийт 13 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгосон, нийт 22 албан хаагчийн албан тушаалын цалингийн шатлалыг ахиулсан нь УИХ-ын 2017 оны 29-р тогтоолын 4, 5 дахь заалтуудад нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолын 4, 5 дахь заалтыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, энэ талаар шийдвэр гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Материаллаг бус залруулагдаагүй алдаа байхгүй байна.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Хэнтий аймаг дахь Цагдаагийн газрын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй ШТМ-ын зарцуулалт, үндсэн үйл ажиллагааны орлогыг цаашид анхаарах асуудал гэж үзлээ.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Хэнтий аймаг дахь Цагдаагийн газрын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй байна.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Хэнтий аймаг дахь Цагдаагийн газрын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 19.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснийг давтахгүй байх зөвлөмж өгөв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төсвийн захирагчийн 2016 оны санхүүгийн тайланд аймгийн Аудитын газраас хийсэн аудитаар 3 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийн хэрэгжилт 90 хувь байна.

Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:
Зөрчилгүй санал дүгнэлт

Хэнтий аймаг дахь Цагдаагийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан 10 хуудас, аудитын гэрчилгээ 2 хуудас, менежментийн захидал 5 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

Аудитын тайланг


Хянасан:

Дарга,
Тэргүүлэх аудитор

Аудитын менежер

Бэлтгэсэн:

Аудитор



Огноо: 2018.02.23

Ч.Эрдэнэбаатар

Д.Оюунтуяа

Х.Еркегүл

**Хэнтий аймаг дахь
Төрийн аудитын
газар**

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН
2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1 Орлогын талаар.....	2
Асуудал 2 Зардлын талаар	3
Асуудал 3 Байгууллагын үйл ажиллагааны талаар.....	4

2018 оны 02 дугаар 27 сар

Менежментийн захидал

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Төсвийн шууд захирагчид зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Хэнтий аймаг дахь Цагдаагийн газрын дарга, нягтлан бодогч нарт талархал илэрхийлье.

Ажиллалт

1. Үндсэн үйл ажиллагааны орлогын 4.0 сая төгрөгийг шийдвэргүйгээр нэмэлт төсвийн дансанд шилжүүлэн авч зарцуулсан нь:
 - 1/ Сангийн сайдын 2017 оны 216 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын 3.6-д “Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогын давсан хэсгийг энэ журамд заасны дагуу шийдвэр гарсны дараа нэмэлт төсвийн дансанд шилжүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.
2. Туслах үйл ажиллагааны орлогын 3.4 сая төгрөгийг төсвийн дансанд тушаахгүй, төсвөөс гадуур зарцуулсан нь:
 - 1/ Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-д “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

1. Санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгээгүй байх
2. Холбогдох хууль тогтоомжийг мөрдөхгүй байх

Зөвлөмж

1. Сангийн сайдын 2017 оны 216 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын 3.6 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах
2. Ноолуурын орлогыг төсвөөс гадуур зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, харилцах дансандаа тушааж холбогдох журмын дагуу зарцуулж байх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчлийг төсвийн захирагчид танилцуулахад хүлээн зөвшөөрсөн албан тоот ирүүлсэн болно.

Ажиглалт

Цалингийн зардлаас 6.8 сая төгрөгийг НДШ-ийн зардалд шилжүүлэн зарцуулсан нь:

1/ Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар"-т нийцэхгүй байна.

2. Үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагааны зардалд зориулж 5.4 сая төгрөгийг малчны цалинд олгосон нь:

1/ Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3-д "Үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагааны зардалд зориулж шууд болон шууд бусаар хөрөнгө зарцуулахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

2/ Үнэн зөв байдал: "Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, **зөв хураангуйлж бүртгэсэн** болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх" гэсэн санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Зөвлөмж

3. Төсвийн тухай хуулийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг мөрдөж ажиллан, батлагдсан төсвийн зарлагыг эдийн засгийн ангиллын дагуу бүртгэж байх

4. Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3-д "Үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагааны зардалд зориулж шууд болон шууд бусаар хөрөнгө зарцуулахыг хориглоно" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах

Эрсдэлүүд

Холбогдох хууль тогтоомжийг мөрдөхгүй байх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчлийг төсвийн захирагчид танилцуулахад хүлээн зөвшөөрсөн албан тоот ирүүлсэн болно.

АГ-ын ажиглалт

2017 оны 5 сарын 1-нээс хойш нийт 13 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгосон, нийт 22 албан хаагчийн албан тушаалын шалингийн шатлалыг ахиулсан нь УИХ-ын 2017 оны 29-р тогтоолын 4, 5 дахь заалтуудад нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Холбогдох хууль тогтоомжийг мөрдөхгүй байх

АГ-ын зөвлөмж

1. УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолын 4, 5 дахь заалтыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, энэ талаар шийдвэр гаргахгүй байх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчлийг төсвийн захирагчид танилцуулахад хүлээн зөвшөөрсөн албан тоот ирүүлсэн болно.

Дээрх өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж, биелэлтийг 2018 оны 6 сарын 25-ны дотор Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт бичгээр ирүүлэх.


МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

Д.ОЮУНТУЯА

Х.ЕРКЕГҮЛ

БЭЛТГЭСЭН:

Огноо: 2018.02.26